

~ Японы талаар илүү сайн мэдэж авцгаая ~

2024 оны 4 дүгээр сар,
Хаврын дугаар

Сэдэв

Манганаас мэдэж авцгаая, Японы дүрэм “Хог хаях арга”

◇ Япон дахь амьдралаа улам баяжуулаарай! ~NHK ワールド JAPAN-ыг туршиж үзээрэй~

◇ “хирагана”, “катакана”-гийн гарал үүсэл

Хэлний ой, “Төстэй утгатай үгнүүд”

Манганаас мэдэж авцгаая, Японы дүрэм

— Хог хаях арга —



Хогоо ялгалгүйгээр, юу ч хамаагүй хольж хутгаад хогны цэг дээр тавьчих юм бол хогийг зөв боловсруулж, дахин боловсруулах боломжгүй болчих ба хог боловсруулах газарт осол үүсгэчих тохиолдол ч байдаг. Оршин суугаа бүсийнхээ хог ялгах тогтсон дүрэм болон хог цуглуулах өдөр, цаг г.м дүрмийг баримтлахгүй бол, хогны цэгт олон хог удаан хугацаагаар хуримтлагдаж, хогны цэг бохир, муухай үнэртэй болно. Тогтсон дүрмийг заавал баримтлаарай.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна.
(<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)



Япон дахь амьдралаа улам баяжуулаарай!

Японд амьдрахад үнэн зөв мэдээллийг олж мэдэх нь маш чухал юм. Японы олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох NHK-гийн глобал үйлчилгээ “NHKワールドJAPAN” нь телевиз, радио, интернетээр дамжуулан төрөл бүрийн мэдээллийг гадаадын олон хэл дээр хүргэдэг. Япон хэл суралцахад хэрэг болох контент болон газар хөдлөлт г.м том хэмжээний байгалийн гамшиг гарсан үед шуурхай мэдээллийг ухаалаг утас руу мэдээлдэг аппликейшн ч байдаг. QR кодыг нь уншуулаад туршиж үзээрэй.

NHK WORLD-JAPAN аппликейшн татаж аваарай!

- ☆ Япон хэл суралцахад зориулсан контент ч олонтой
 - ☆ NHK-гийн мэдээг 19 хэл дээр хүгэдэг.
 - ☆ Глобал нэвтрүүлгийг зэрэг хүргэдэг + олон хэлний хадмал орчуулгатай
 - ☆ Телевиз, радиогийн нэвтрүүлгийг хүсэлтийн дагуу хүргэдэг.
 - ☆ Газар хөдлөлт, цунамигийн шуурхай мэдээллийг ухаалаг утас руу мэдээлдэг.
- ※ Англи, Хятад, Вьетнам, Португал хэлээр хүргэнэ.



ХОлон хэлний мэдээллийн нэвтрүүлэг “Living in Japan”

NHK ラジオ第2 -оор мөн мэдээлнэ.

Нэвтрүүлгийн өдөр, цаг: Долоо хоног бүрийн Ням гаригийн 13:10-30 минут [Дахин нэвтрүүлэг] Дараагийн долоо хоногийнх нь Бямба гариг Нэвтрүүлэх хэл: Англи, Хятад, Вьетнам, Португал хэл (Долоо долоо хоногоор ээлжилнэ.)

Японд амьдардаг гадаад хүмүүст хэрэг болох мэдээллийг тус бүрийнх нь коммюнитид нийцүүлсэн агуулгатайгаар хүргэнэ.



Chatroom Japan

Японд амьдардаг гадаад хүмүүсийн саналыг нь сонсох нэвтрүүлэг. Вебсайттайгаа мөн уялдаж, Япон дахь амьдралын сайн тал болон ойлгомжгүй талын тухай шинэ соргог өнцгөөс харна. Санал болон санаа зовж буй зүйлийг хүлээн авч байна!



Мэдээ

NHK WORLD-JAPAN-ыг WEBсайт, аппликейшнаар шууд дамжуулан үзэх боломжтой.

NHK NEWSLINE (Даваа-Баасан) цаг бүрийн 00 минутаас / (Бямба, Ням) цаг бүрийн 00 минутаас ※ Мягмар-Бямба гаригийн өглөөний 4 цагаас бусад

NHK WORLD-JAPAN-ы гол мэдээнүүдийн нэвтрүүлэг. Өдөр бүр цаг бүрийн 00 минутаас, Японы болон азийн голцуу дэлхийн хамгийн шинэ мэдээ, эдийн засгийн мэдээлэл, цаг уурын мэдээлэл зэргийг хүргэнэ.

■ NEWSLINE ASIA 24 (Даваа-Баасан) 15:00

Азийн орнуудаас шууд дамжуулах г.м мэдээ хүргэх NHKNEWSLINE-ы өргөтгөсөн хувилбар.

■ NEWSLINE IN DEPTH (Даваа-Баасан) 20:27

Олны анхаарал татсан мэдээг гүнзгийрүүлж дамжуулахаас авахуулан орон нутгийн гэрэл гэгээтэй сэдэв хүртэл аливаа үйл явдлын үнэнийг хөөнө.

■ NEWSROOM TOKYO (Даваа-Баасан) 20:00

Ажлын өдрийн шөнө Япон болон азийн 1 өдрийн үйл явдлыг тусгайлан авч үзэж, мэргэжилтнүүд болон сурвалжилсан сурвалжлагчдын тайлбарыг оролцуулан, гүнзгий бөгөөд ойлгомжтойгоор дамжуулдаг мэдээний нэвтрүүлэг.

ANIME MANGA EXPLOSION

Гадаадын фенүүдэд ч танил болсон төлөөлөх бүтээлийг идэвхтэйгээр авч үзэн, цувралаар дамжуулан Японы анимэ, манга бүтээх нууцад нэвтэрнэ.



“хирагана”, ”катакана”-гийн гарал үүсэл

Япон хэлний “фонограм (дангаараа бол утга агуулдаггүй, авиат үсэг)”-д “хирагана”, “катакана” гэсэн 2 төрөл байдаг. Энэ нь “идеограм (дангаараа тодорхой утга агуулдаг үсэг)” болох “ханз”-наас үүссэн Японы онцлог үсэг юм. Тэгвэл ижил авиатай үсгэнд яагаад “хирагана”, “катакана” гэсэн 2 төрөл байдаг юм бол?

Юуны өмнө “ханз” нь 1-р зууны үед Хятадаас Японд орж ирсэн гэж үздэг. Тэр үе хүртэл Японд үсэг байгаагүй ба Хятадаас орж ирсэн ханзыг хэрэглэх болсон. Гэвч Хятадаас орж ирсэн ханз дангаараа бол Япон хэлийг хангалттай илэрхийлэх боломжгүй байсан тул ханзнаас утгыг нь орхиж, зөвхөн авиаг нь аван, Япон хэлийг илэрхийлэх болсон. Энэ нь “ман-ёо-гана” юм. Тухайлбал, хираганагийн “も” нь ман-ёо-ганагаар бол “毛”-ээр илэрхийлж байсан. Японы хамгийн эртний вака шүлгийн цуглуулга гэж үздэг “ман-ёо-сю”-д хэрэглэгдсэнээс ийнхүү нэрлэгдэх болсон гэж мөн үздэг.

Гэхдээ ман-ёо-гана нь олон төрөлтэй бөгөөд ээдрээтэй, бичихэд хэцүү үсэг ч олон байсан. Ингээд 9-р зууны үед ман-ёо-ганаг задалж үүссэн үсэг нь “хирагана” юм. Энэ үе бол Хэй-аны үе гэгддэг язгууртны соёлын үе юм. Тухайн үед эрэгтэйчүүд албандаа ханзыг хэрэглэж байсан ба “хирагана” нь голцуу хувийн хэрэглээнд хэрэглэх, мөн эмэгтэйчүүдийн хэрэглэх үсэгт тооцогдож байсан. Тэр хүртэл эрдэмтэн г.м маш цөөн тооны хүмүүс л

тайлагдсан байсан бичиг үсэгт илүү олон хүмүүс тайлагдсанаар, захидал болон эссэ, вака шүлэг зэрэг хөгжиж, эмэгтэйчүүдийн уран зохиол өргөн хүрээнд дэлгэрэхэд түлхэц болсон. Одоо телевизээр нэвтрүүлэгдэж буй NHK-гийн түүхэн цуврал драмын гол дүр болох Мурасаки Шикибүгийн туурвисан “Гэнжи моногатари” нь энэ үеийг төлөөлөх уран зохиолуудын нэг юм.

Нөгөөтэйгөөр, “катакана”-г ман-ёо-ганагийн нэг хэсгийг таслан авч үүсгэсэн гэж үздэг. Голцуу эрэгтэйчүүд ханз бичгийг суралцахдаа тэмдэглэгээ хийхэд зориулан үүссэн үсэг гэж үздэг.

“ханз”, “хирагана”, “катакана” гэсэн 3 төрлийн үсэг хэрэглэдэг улс ховор бөгөөд тийм ч учраас Япон хэлийг суралцахад хэцүү хэл гэж ярьдаг. “хирагана”, “катакана”-гийн гарал үүсэлтэй танилцаж, улам илүү сонирхолтойгоор Япон хэлээ гүнзгийрүүлэн суралцаасай хэмээн хүсч байна.



(зүүн) ман-ёо-ганагаас катакана руу,
(баруун) ман-ёо-ганагаас хирагана руу

Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)

意味がにている言葉(いみがかいていごころば)をえらんで(ごころば)に書きましょう。(いみがかいていごころば)

こくごのもり (こくごのもり)

指導・元世田谷区立小学校教諭 高橋 信子 (たかはし のぶこ) イラスト・奈良 恵 (なら けい)

Инээмсэглэсэн зураг



Миэ мужийн Цү хотод зохион байгуулагдсан “20 настнуудын баярын ёслол”-д кимоно өмсөж оролцсон Индонезийн ур чадварын дадлагажигч нар. Ёслолын дараа Нарагийн Тоодайжи хийдэд очсон. Японд насанд хүрсний баярын ёслолын ажиллагаанд оролцож чадсандаа маш их баяртай байгаа ба мартахын аргагүй дурсамж боллоо. Ийм боломжийг олгож өгсөн ажлын газрынхаа хамт олонд талархаж байна.

※2024年1月投稿 実習実施者：旭電器工業株式会社（監理団体：ELC事業協同組合）

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн 32-р уралдааны танилцуулга

JITCO нь 4-р сарын 1 (Даваа)-наас Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд оролцох бүтээлийг хүлээн авна. Бүтээл ирүүлэх цаад хугацаа: 5-р сарын 10 (Баасан). Уралдааны дэлгэрэнгүй удирдамжийг JITCO-гийн цахим хуудас (<https://www.jitco.or.jp/>), JITCO Япон хэлний сурах бичгийн хироба (талбай) (<https://hiroba.jitco.or.jp/>)-гийн “Мэдээлэл”-д нийтэлсэн байгаа. Та бүхнийг уралдаанд оролцохыг урьж байна!



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

Асуудал тулгарсан үед ...? (<https://www.otit.go.jp/notebook/>)

ОТИТ (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばの にほんご /Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



“におい/ниой/үнэр”-энд гоё үнэр, муухай үнэр байдаг ба “かおり/каори/үнэр”-г “いい匂い/ий ниой/гоё үнэр”-г илэрхийлэхэд хэрэглэдэг. “かがやく/кагаяку/гялалзах”-г “きらきら光る/кира кира хикару/гялтганан гялалзах”-г илэрхийлэхэд хэрэглэдэг. “にぎる/нигирү/атгах” гэдэг нь “бүх хуруугаа дотогш нь нугалах”. Тэр байдлаараа “物をつかむ/моно о цукаму/юм барьж авах” гэсэн утгыг мөн илрхийлнэ. Том дуу гаргавал “叫ぶ/сакэбу/хашгирах”, түүн дотроо эмоци ширүүсвэл “怒鳴る/донару/зандрах”, үймээн шуугиан дэгдээвэл “喚く/вамэку/орилж чарлах” болно.

とも

2024年4月 春季号

2024年4月1日発行

発行

電話

JITCO ホームページ

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

<https://www.jitco.or.jp/>